



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/55

Бүрэн сум

Өвөлжөө, хаваржааны бүс нутаг
чөлөөлөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжөө, хаваржааны бүс нутгийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд малын хөлөөс чөлөөлж айл өрх, оторчдыг оруулахгүй байх ажлыг зохион байгуулсугай.

2.Өвөлжөө, хаваржааны бүс нутгуудад байгаа айл өрхүүдийг нүүлгэж бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх ажлыг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Отгонхишигт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500130